


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд:

“XI.8. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Замын цагдаагийн албыг тээврийн хэрэгслийн хурд хэмжих багаж, мансуурал шалгах тестээр хангах, орон нутгийн авто замын хөдөлгөөнд орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглан хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх талаар судалгаа хийх, стандартын шаардлага хангаагүй мотоцикл, түүний сэлбэг хэрэгслийг импортоор оруулахыг хориглох чиглэлээр санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР